



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 19/69

Мандалговь

“Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Самданцоодол (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод
аудитын хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл)

Ө.Дугармаа (Зах зээл ба бэлчээрийн удирдлагын
хөгжил төслийн зохицуулагч)

С.Адъяасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ХАА
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Самданцоодол)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060274